



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1337  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИХ ИРГЭН Д.ОРГИЛ  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Долгорын Оргилын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Иргэн Долгорын Оргилын Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн


хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Долгорын Оргилын сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
Д.ОРГИЛЫН “ШИНЭ МЯНГАН 21” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.07.23

Улаанбаатар хот

Шинэ мянганы босгон дээр тусгаар улсын нийслэл Улаанбаатар хот нь их хотын хэмжээнд төлөвлөгдсөн, алсыг харсан хөгжлийн төлөвлөлттэй, бизнесийн болоод амьдрах орчны илүү таатай орчин бүхий хот байх ёстой. Үүний тулд сууриа зөв тавьсан, зөв төлөвлөгдсөн хот байхын төлөө ирэх 4 жилийг дахин төлөвлөлтийн үе болгох шаардлагатай.

**Бодлого 1: Дэд бүтцийн төлөвлөлт:**

- 1.1. Хотын дэд бүтцийн хувьд хамгийн эхэнд анхаарах зүйл бол үе усны хамгаалалт, ус зайлуулах, нөөцлөх, дахин ашиглах төлөвлөлт байх ёстой.
  - Хотын үерийн усны урсац, хуримтлал, голдирллыг тандан судлах ажлыг хийнэ.
  - Уулын ус хураах талбайн судалгаа хийж, үерийн усны гол гол судлуудыг тогтооно.
  - Үерийн усны судлуудад тулгуурлан далан, сувагчлал байгуулах төлөвлөлт хийнэ.
  - Үерийн усыг зайлуулах, гол цутгах магистрал шугам, хоолой, сувагчлалын тооцоог хийж төлөвлөнө.
  - Үерийн усыг нөөцлөх ил болон далд байгууламжуудыг төлөвлөх, түүний ус цэвэрлэх, эргүүлэн ашиглах тооцоо судалгааг хийж батлуулна.
- 1.2. Инженерийн байгууламжийн төлөвлөлтийг дахин шинэчилж, төвлөрсөн болон бие даасан шийдлүүдийг гарган, түүнд тулгуурласан дэд бүтцийн хүртээмжийг зураглах, тооцоолох ажлыг эхлүүлнэ.
  - Хотыг тэлэх бодлого, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан, хүн амын суурьшил, нягтаршилын тооцоонд тулгуурлан инженер байгууламжын төлөвлөлтийг дахин шинэлчэн төлөвлөнө.
  - Инженерийн байгууламжийн насжилтыг уртасгах зориулалтаар илүү чанартай материал, илүү бат бөх шугам хоолойн байгууламжийн технологийг боловсруулан амьдралд нэвтрүүлж ажиллана.
  - Иргэдэд эрүүл, аюулгүй ундны ус нийлүүлэхийн тулд “зэс хоолой” хөтөлбөр боловсруулан, түүний стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.
  - Бохир ус зайлуулах технологийг сайжруулж, бохир ус зайлуулах “тунель” хоолойн зураг төслийг боловсруулах, шинээр төлөвлөлт хийх ажлыг эхлүүлнэ.
  - Инженерийн байгууламжийн дэд төв байгуулах ажлыг дэмжин, үргэлжлүүлэх бөгөөд түүнийг гэр хороололд олноор байгуулах замаар хот төлөвлөлтийг тэлэх, гэр хорооллын орчныг сайжруулах, газрыг үнэ цэнэтэй болгох замаар эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлнэ.
- 1.3. Авто замын төлөвлөлтөд замын чанарыг шинэ шатанд гаргах, илүү чанартай, урт настай зам барих, замын ажлыг ус зайлуулах шийдэлтэй салшгүй холбоотой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
  - Нийслэлийн авто замын чанар, стандартыг сайжруулна.

- Замын чанар, материалын чанарт илүү анхаарч, шинэ стандарт мөрдүүлэх, зам барих, хянах, хүлээн авах тогтолцоонд ахиц гаргана.
- Зам барих ажлыг ус зайлуулах ажлаас ангид байдаг асуудлыг өөрчлөн, замын байгууламжийн бүрдэл хэсэгт ус зайлуулах шийдлийг багц болгон уялдуулна.
- Авто замын бүтээн байгуулалтыг зөвхөн авто машинд бус явган болон 40 км/ц хүртэлх хурдтай дугуй, мопед, бага оврын цахилгаан төхөөрөмж зорчих нөхцөлийг тооцсон төлөвлөлтөөр барих стандарт бий болгоно.
- Авто замын ажилд хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих шийдлийг зайлшгүй тусгуулна.

## **Бодлого 2: Архитектур төлөвлөлт**

- 2.1. Хот төлөвлөлтийг өнөөдрөөр бус ирээдүйг харсан байхаар төлөвлөх ба ирээдүйгээ зөв тодорхойлж, төвлөрсөн байдлаас илүү хүртээмжтэй байдалд илүү анхаарч, урьдчилан харж төлөвлөнө.
- 2.2. Ухаалаг хот байх алхамыг хийж, хот төлөвлөлтийг дахин төлөвлөх ажлыг эхлүүлнэ.
- 2.3. Хот төлөвлөлтийг байшин барилгаас илүү дэд бүтцийг харгалзсан шийдэлд илүү анхаарч ажиллана.
- 2.4. Ногоон хот байх талаас илүү төлөвлөнө.
- 2.5. Байшин хоорондын зайн стандартыг хатуу баримтлах бодлого баримтлана.
- 2.6. Одоо байгаа байр хоорондын талбай, ногоон байгууламжид дахиж нэг ч барилга барихгүй, нэг ч ногоон байгууламж, тоглоомын талбай сүйтгэхүй байх журам боловсруулна.
- 2.7. Хуучин, ашиглалтын шаардлага хангахгүй барилга, орон сууцны хорооллыг дахин төлөвлөх замаар шинэ хотын өнгө үзэмжийг бий болгоно.

## **Бодлого 3: Ухаалаг хот төлөвлөлт**

- 3.1. Хотын үйлчилгээ бүр ухаалаг шийдэлд шилжих замаар дата цуглуулан, иргэнээ мэдэрсэн үйлчилгээ бүрийг өдөр тутам сайруулан ажиллах нөхцлийг бий болгоно.
- 3.2. Иргэн ба төр хоорондын харилцаанд ухаалаг шийдэл нэвтрүүлнэ.
- 3.3. Иргэд төрөө хянах системийг цахимжуулна.
- 3.4. Иргэн төрийн үйл хэрэгт оролцох, төлөөллийн болон шууд ардчиллын механизмыг шингээсэн цахим тогтолцоог бий болгоно.
- 3.5. Төрийн үйлчилгээг “цаасгүй төр” хөтөлбөрт шилжүүлнэ.
- 3.6. Төрийн болон нийтийн үйлчилгээний давхардлыг арилгах ажлуудыг бизнесийн байгууллагуудын оролцоотой шийдвэрлэнэ.

